

**Статистикийн хэлтсийн 3 дугаар сарын 30-наас 4 дүгээр сарын 05-ны  
өдрийг хүртлэх 7 хоногт хийсэн  
ажлын товч мэдээ**

2018.04.05

Өлгий хот

1. Үндэсний статистикийн хороо, Эрүүл мэндийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамны хамтарсан төлөвлөгөө, удирдамжийн дагуу 2018 оны 03 дугаар сарын 25-наас 31-ний өдрийн хооронд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх багтай хамтран Толбо, Бугат, Өлгий сумуудад хяналтаар ажиллав.
2. Нийгмийн халамжийн салбарын сарын мэдээ, Аж үйлдвэр, Тээвэр, барилгын салбарын мэдээ болон Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2017 оны гүйцэтгэлийн мэдээг /ХО-ЗБ/ холбогдох газар, хэлтсээс авч, хянан нэгтгэж ҮСХ-нд мэдээлэв.
3. Хөдөлмөр, халамж үйлчилгээний газраас хийгдсэн хөдөлмөрийн зах зээлийн тоон болон чанарын судалгааны тайлангийн номын эхний хэсэгт орсон өнөөгийн байдлын талаарх тойм танилцуулгыг бичиж өгөв.
4. Хэлтсийн портал сайтанд 7 хоногийн үнийн өөрчлөлтийн мэдээг оруулав.
5. Хүнсний гол нэрийн барааны үнийн мэдээг 7 хоног бүрийн лхагва гарагт цуглуулж, төв руу дамжуулав
6. Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа болон ажиллах хүчний судалгааг үнэн бодитоор авч байгаа эсэхийг утсаар тодруулж, зайн хяналт хийв.
7. Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа болон ажиллах хүчний судалгааг сумуудаас сонгогдсон нэгжээс авч, хянаж ҮСХ-нд хугацаанд нь онлайнаар хүргүүлэв.
8. Мал төллөлт, бойжилтын мэдээ, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн мэдээ болон том малын зүй бус хорогдлын мэдээг сумуудаас нэгтгэн авч, хугацаанд программд оруулав.
9. Албан ёсны статистикийн мэдээний хамралтыг сайжруулах үүднээс шинээр байгуулагдсан 3075176-Күмис Ине ХХК, 3075249-Асыл бүби ХХК компаниудыг аж үйлдвэрийн мэдээнд хамруулав.
10. жилийн эцсийн ААНБ-1, ААНБ-2 мэдээ тайлангийн ISIC болон сангийн яамны тодруулгыг хийж хугацаанд нь зохих газарт хүргүүлэв.
11. Үндэсний статистикийн хорооноос орон нутгийн ажилтнуудад зориулсан SPSS, E-VIEWS статистикийн програмын сургалтад Ахлах мэргэжилтнийг оролцуулав.

12.Бизнес регистрийн 1-р улирлын 72 ААНБ-ын мэдээг цуглуулж хугацаанаас өмнө БРС-нд нэмсэн. Нэр нь давхардсан 2 ААН-ийн мэдээллийг ҮСХ-ны Бизнес регистрийн багт танилцуулан зохих журмын дагуу БРС-нд нэмж оруулав.

### **Статистикийн хэлтэс**